



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2016 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/194

Мөрөн

Цагийн хязгаарт зохицуулалт хийх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улс нь зуны цагийн хуваарьт шилжсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн “Цагийн хязгаар тогтоох тухай” А/10 дугаар захирамжаар батлагдсан согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй худалдааны газрын үйл ажиллагааг явуулах өвлийн цагийн хязгаарыг 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд өглөөний 06:00 цагаас оройн 00:00 цаг байхаар зохицуулалт хийсүгэй.

2. Зохицуулалт хийсэн цагийн хязгаарыг мөрдөн ажиллахыг согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрөлтэй газруудын цагийн хязгаарын мөрдөлтөнд байнгын хяналт тавьж, зөрчил гарсан тохиолдолд зөрчлийг арилгуулах арга хэмжээг авахуулж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар Н.Батбаяр, Мэргэжлийн хяналтын газар Д.Лхагвасүрэн, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дарга /Г.Гандэлгэр/-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР